



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ  
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ  
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ  
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2023 оны 02 сарын 17 өдөр

Дугаар А/104

Алтай хот

Гэрээ байгуулах эрх олгох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсэг, 46.1.3 дахь заалт, Үнэлгээний хорооны 2023 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн 02 дугаар зөвлөмжийг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжигдэх ГААОНӨГ/202312009 дугаар бүхий газар хагалах анжис нийлүүлэх ажлыг "Ханасан панзат" ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлэх эрхийг Хүнс, хөдөө аж ахуйн газар (Т.Сүхбаатар)-т олгосугай.

2. Ажлын даалгаврыг үндэслэн холбогдох хууль, журмын дагуу эрх үүрэг захиалагчийн хяналт, хариуцлагыг гэрээнд тодорхой тусгаж, хэрэгжилтийг тайлагнаж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газар (Т.Сүхбаатар)-т үүрэг болгосугай.

3. Ажлын гүйцэтгэл, чанар, санхүүжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Г.Хурцгэрэл), Санхүү, төрийн сангийн хэлтэс (Х.Баатарзориг), Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ)-т тус тус даалгасугай.

ОРЛОГЧ



ГЧИНБАТ